

МОНГОЛ ХЭРЭГЛЭГЧИЙН СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Г. Мөнхбаясгалан, докторант, багш, Худалдаа, маркетингийн тэнхим, Худалдааны Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Хураангуй

Сүү, цагаан идээ бол Монголчууд бидний уламжлалт, зохистой хэрэглээний бүтээгдэхүүн билээ. Гэтэл хүн амын талаас илүү нь суурин амьдарч байгаа өнөө үед сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг зохион байгуулахад нүүдлийн мал аж ахуйн үндсэн хэв шинж, дэд бүтэц, зах зээлийн онцлог, сэтгэлгээтэй холбоотой бэрхшээл учирсаар байна. Энэ нь хот, хөдөөгийн хэрэглэгчдийн хэрэглээний эрс ялгаа, сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах хэмжээ бага байх, импортын хуурай сүүний хэмжээг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Тухайлбал, 1918 онд монгол хүний хоногийн сүүний хэрэглээ 2881,5 гр байсан бол 2011 оны байдлаар 403,3 гр болж буурчээ. Харин хот, хөдөөгөөр нь авч үзвэл жишсэн нэг хүний сарын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээний зөрүү 2,3 дахин буюу хотынхны хэрэглээ 7,7 кг байдаг аж.

Иймд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд төр, засгаас түүхий сүүний бэлтгэл, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, түүхий эдээ эх орноосоо бэлдэж буй сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд засгийн газраас татаас, хөнгөлөлт үзүүлэх, төрөөс хуурай сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор сүүний фермер болон малчдын бүлэг, хоршоодыг хөгжүүлэх, дэмжих чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үгс: Сүү, сүүн бүтээгдэхүүн, Хэрэглээ, Бэлтгэл нийлүүлэлт, Түгээлтийн тогтолцоо

Үндсэн хэсэг

Монголчууд зун, намрын цагт сүү цагаан идээг голчлон хэрэглэж ирсэн нь нүүдлийн мал аж ахуй, хүнсний хэрэглээний уламжлал, байгаль, цаг уур зэрэг олон шалтгаантай холбоотой. Монгол Улсын хүн амын талаас илүү хувь нь нийслэл Улаанбаатар болон бусад суурин газар амьдрах болсноор хүнсний хэрэглээний уламжлалт бүтэц өөрчлөгдсөөр байна. Тухайлбал, 1918 онд монгол хүний хоногийн сүүний хэрэглээ 2881,45 грамм²⁰ байсан бол 2011 оны байдлаар 403,3 грамм²¹ болж буурчээ. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээний бууралтын шалтгааныг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд:

- Манай оронд 1930-аад оноос аж үйлдвэржүүлэх, 1950-иад оноос атар газар эзэмших, нэгдэлжих хөдөлгөөн

өрнөснөөр томоохон хот, суурингууд хөгжиж, улмаар суурин амьдралтай хүн ам бий болсон. Өнөөгийн байдлаар манай улсын хүн амын 66,2²² хувь нь хот, сууринд амьдарч байна. Харин мал аж ахуйн салбар уламжлалт нүүдлийн хэв шинжээ хадгалсаар байна.

- Малчдаас сүүг үйлдвэр, хэрэглэгчдэд хүргэх нийлүүлэлт, түгээлтийн оновчтой тогтолцоо өнөө хүртэл бүрэлдэж чадаагүй байсаар байна. Энэ нь хөдөөгийн жишсэн нэг хүн жилд 211,2 кг сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэсэн байхад хотынхны хэрэглээ түүнээс 2,28 дахин бага байгаагаас харагдана²³.
- Эрүүл, аюулгүй хүнсний эрэлт хэрэгцээ өссөн өнөө үед үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн

²⁰ Майский И., 2001. Орчин үеийн Монгол, хуудас 177, Улаанбаатар


²¹ YCX, 2012. Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 2011, Үндэсний Статистикийн Хороо, хуудас 309, Улаанбаатар

²² YCX, 2011. Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл, Үндэсний Статистикийн Хороо, хуудас 86, Улаанбаатар

²³ YCX, 2011. Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл, Үндэсний Статистикийн Хороо, хуудас 309, Улаанбаатар

бүтээгдэхүүний үйлдвэрлэл маш бага байдаг. ҮХААЯ-ны тооцоогоор сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж 2008-2010 онуудад 125,4-83,9 хувь, үүнээс дотоодын үйлдвэрлэлээр хангасан нь 118,4-78,9 хувьтай байна. Харин хот, хөдөөгөөр авч үзвэл жишсэн нэг хүний сарын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ (Зураг 1) эрс ялгаатай байгаа нь харагдаж байна.

Зураг 1: Жишсэн нэг хүний сарын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ, кг



Эх үүсвэр: Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл, 2007-2011

Энэ судалгааны ажлын хүрээнд манай орны сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн жилийн багтаамжийг тодорхойлсон бөгөөд жишсэн нэг хүний хоногийн физиологийн норм, одоогийн бодит хэрэглээний талаарх мэдээллийн хоёрдогч эх үүсвэрт тулгуурлан тооцов.

Үндэсний статистикийн хорооноос 2008 онд хийсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар нэг хүн хоногт 169 (сард 5070) төгрөгний сүү, сүүн бүтээгдэхүүн болон өндөг хэрэглэдэг ажээ. Энэ хэрэглээнээс өндөгний хэрэглээг нь хасаж тооцвол нэг хүний сүү, сүүн бүтээгдэхүүний сарын хэрэглээ 4495 төгрөг ба Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн жилийн багтаамж 142,2 гаруй тэрбум төгрөг байна.

Эрүүл мэндийн яамны сайдын 2008 оны 12 сарын 4-ний өдрийн "Хүн амын хоол тэжээлийн физиологийн нормыг батлах тухай" тушаалын дөрөв, тавдугаар хавсралтад зааснаар жишсэн нэг хүний хоногийн сүүний жишиг норм сэрүүний улиралд 150 грамм, зуны улиралд 200 грамм, тараг, аарцных 200-295 грамм гэснийг үндэслэн сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн нийт боломжийг тооцоход 350,0 мян.тн, үүнээс хот суурингийнх 219,4 мян.

тн байна²⁴. Дээрх тооцооллоос харахад сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн багтаамж нэлээд их байгааг харж болно. Энэ нь сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр бизнес эрхлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх боломж байгааг харуулна. Сүүг боловсруулан органик хүнс үйлдвэрлэх боломжтой боловч үйлдвэрийн аргаар боловсруулж буй хэмжээ харьцангуй бага байсаар байна (Зураг 2).

Зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангах сүүний нийлүүлэлт, хангамж ямар байгааг судалж үзье. Сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг оновчтой зохион байгуулахын тулд чанар, эрүүл ахуй, хөргөлт, хадгалалт, тээвэрлэлтийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай болдог ба энэ нь нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй үед шийдвэрлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байдаг.

Манай орны сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн гол нийлүүлэгчид нь малчид фермер, дотоодын үйлдвэр, импортлогчид байна.

²⁴ Тооцоог хийхдээ зуны улиралд жишсэн нэг хүн 495 грамм, бусад үед 350 грамм сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэнэ гэж үзсэн болно.

Судлаачдын тооцоогоор манай улс жилдээ 631²⁵ сая литр сүү саах боломжтой боловч 60-70 орчим хувийг нь сааж, саасан нийт сүүнийхээ 70 хувийг нь зах зээлд нийлүүлдэг гэсэн тооцоог ҮХААЯ-

ны мэргэжилтнүүд хийсэн байна. Өөрөөр хэлбэл, хамгийн том нийлүүлэгчид болох малчид, фермерүүд нөөц бололцоогоо бүрэн ашиглахгүй байна гэсэн үг.

²⁵ ММCG, 2010. «Сүү боловсруулах үйлдвэр»-ийн техник-эдийн засгийн үндэслэл, Бизнесийн судалгааны "ММCG" ХХК болон МУИС-ийн хамтарсан судалгааны баг, хуудас 7, Улаанбаатар, хэвлэгдээгүй

Зураг 2: Сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлт, мянган тонн



Эх үүсвэр: ГЕГ (2012). Монгол Улсын болон Гадаад худалдааны барааны статистикийн эмхэтгэл, 2011, Гаалийн Ерөнхий Газар, Улаанбаатар

Олон улсын сүү, сүүн бүтээгдэхүүний холбоо /IDF/-ны 2009 оны тайлан илтгэлээс үзвэл дэлхийн сүүний боловсруулалтын дундаж төвшин 52,3 хувь байгаа бол 2011 оны байдлаар манай улсад энэ үзүүлэлт 3,6 хувьтай байна. Энэ нь манай улсад эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлт хангалтгүй, өөрөөр хэлбэл зах зээлд нийлүүлэгдэж буй сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулалтын төвшин доогуур, чанар эрүүл ахуйн лабораторийн шинжилгээнд бүрэн хамрагдаагүй зэрэг сул талтай байна гэсэн хэрэг.

Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ харьцангуй бага байгаа нь бэлтгэл, түгээлтийн оновчтой системийг бүрдүүлж чадаагүйгээс үйлдвэрүүд түүхий эдийг хангалттай түвшинд цуглуулж авч чадахгүй байгаатай холбоотой. Малчид, фермерүүдийн бэлтгэсэн сүүг үйлдвэрүүдэд нийлүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг мал аж ахуйн, дэд бүтцийн, зах зээлийн, компанийн гэсэн хэсгүүдээр тодорхойлов (Зураг 3).

Зураг 3: Сүүний бэлтгэл, нийлүүлэлтэд учирч буй бэрхшээл

Мал аж ахуйн хүчин зүйл:	Дэд бүтцийн хүчин зүйл:	Зах зээлийн хүчин зүйл:	Компанийн хүчин зүйл:
• нүүдлийн мал аж ахуй • байгаль, цаг агаараас хамааралтай • саалийн хугацаа богино • сүүний гарц бага, эмзэг бүтээгдэхүүн • малын эрүүл мэндэд хангалттай хэмжээнд анхаардаггүй	• аймаг, сум хоорондын зам тээврийн сүлжээ хөгжөөгүй • хөдөө орон нутагт эрчим хүчний эх үүсвэр бүрэн шийдэгдээгүй • эрүүл ахуй, чанарын шинжилгээний лаборатори, тоног төхөөрөмж хангалтгүй	• ихэнх хэрэглэгчид уламжлалт аргаар боловсруулсан сүү цагаан идээг хэрэглэх сонирхолтой	• ихэнх нь жижиг дунд үйлдвэрүүд • санхүү, машин тоног төхөөрөмж, ажиллах хүчний хангалттай нөөцгүй

Монголын уламжлалт нүүдлийн мал аж ахуй нь байгаль, эрс тэрс уур амьсгалдаа зохицсон, саалийн хугацаа богино, гарц бага байдаг зэрэг нь жилийн турш зах зээлийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахад гол саадыг бий болгож байна. Энэхүү бэрхшээлийг даван туулах үндсэн гарц нь сүү сааль элбэг зуны саруудад сүүг цуглуулан хуурай сүү үйлдвэрлэж, өвөл, хаврын цагт хуурай сүүгээ сэргээн шим сүү үйлдвэрлэх нь зүйтэй. Тэгтэл хуурай сүүний үйлдвэр байгуулахад дэд бүтэцтэй холбоотой нэлээд асуудлууд байгаа боловч, эхний ээлжинд аймгийн төвүүдэд байгуулах замаар үүнийг шийдэх боломжтой гэж үзэж байна.

Бидний судалгаанаас үзвэл хөдөө орон нутгийн нас тогтсон хүмүүст үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү нь элдэв үнэр амттай, мөн хуурай сүү найруулдаг тул чанар нь сайн биш гэсэн буруу ойлголт байдаг нь ажиглагдсан. Харин хот, суурингийн залуу болон дундаж насны хэрэглэгчдийн хувьд сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдан авахдаа эрүүл ахуйн шаардлагыг хэр хангасан болохыг нь харгалзан авдаг жишиг бий болсон нь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан “Үдийн цай” хөтөлбөр нь энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх томоохон хөшүүрэг юм. Мал аж ахуй, дэд бүтцийн хүчин зүйлс, бүтээгдэхүүний эмзэг байдлаас шалтгаалан ихэнх компаниуд энэ чиглэлийн бизнест хөл тавьдаггүй. Гэхдээ эдгээр эрсдлийг даван туулахын төлөө хоногт 220 гаруй тонн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай 90 гаруй үйлдвэр, цех ажиллаж, 20 гаруй нь жилийн турш үйл ажиллагаа явуулдаг байна²⁶.

Хүнсний аюулгүй байдал, экологийн цэвэр хүнсний асуудал хурцаар тавигдсан өнөө үед хот, суурингийн хүн ам сүү, цагаан идээг хэрэглэх хүсэл сонирхол нь нэмэгдэж

буй боловч зах зээл дээрх бүтээгдэхүүн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тэр бүр нийцэхгүй байгаа нь импортын хэмжээг нэмэгдэхэд хүргэж байх талтай.

Сүүлийн найман жилийн хугацаанд импортын сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 6,0-аас 6,5 мянган тонн (Зураг 2) болжээ. Импортын сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрлийг авч үзвэл нэлээд сонирхолтой байдал ажиглагдаж байна. Барааг Тодорхойлох Кодлох Уялдуулсан Систем-ийн ангиллаар авч үзвэл, 2011 онд 24 зүйлийн сүү, сүүн бүтээгдэхүүн импортолсны 56 орчим хувийг хуурай болон шингэн сүү, үлдэх хувийг цөцгийн тос, аарц, бяслаг, тараг, цөцгий, өтгөрүүлсэн болон бусад хольцоор баяжуулсан сүү гэх мэт бүтээгдэхүүн эзэлж байна. 2004 оноос нийт сүү, сүүн бүтээгдэхүүний импортын дүнд хуурай сүүний эзлэх хувь 17,1-ээс 54,1 болтлоо нэмэгдэж, шингэн сүүний импорт 78-аас 1,9 хувь хүртэл импорт буурчээ²⁷.

Импортын хуурай сүүний нийлүүлэлт эрс нэмэгдсэний шалтгаан нь айл өрхийн эрэлт хэрэгцээ өссөн асуудал огт биш бөгөөд Засгийн газраас “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, хот суурингийн хүн амын үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэх хүсэл сонирхол нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсээс улбаалан энэ чиглэлийн үйлдвэрүүдийн түүхий эдийн эрэлт өссөнтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрүүд боломжийн зардлаар, төвөг багатайгаар түүхий эдээ бэлтгэн авах гол арга зам нь хуурай сүүг импортлон оруулж ирэх болоод байна.

2003 онд импортын хуурай сүүний 50 хувийг ОХУ-аас авч байсан бол 2011 онд 0,7 хувьд хүрсэн байна. Манай улс 2004 оноос Шинэ Зеландаас хуурай сүү импортолж эхэлсэн бөгөөд 2011 онд манай хуурай сүүний импортийн 96,7 хувийг дангаараа нийлүүлэх болсноор

²⁶ ҮХААЯ-ны вэб сайт <http://mofa.gov.mn/>

²⁷ ГЕГ, 2012. Гадаад худалдааны барааны статистик- 2011, Гаалийн Ерөнхий Газар, хуудас 15, Улаанбаатар

манай хамгийн том түнш болж, харин ОХУ гуравдахь том нийлүүлэгч болжээ²⁸.

Манай улсын шингэн сүүний импортод ОХУ тэргүүлэх байр суурийг эзэлсэн хэвээр байна. Тус улс 2003 онд манай шингэн сүүний импортын 99,8 хувийг дангаараа нийлүүлж байсан бол 2007-2008 онуудад БНХАУ-д зах зээлээ алдаж 62,6 хувь болтлоо буурчээ. ОХУ зах зээлийн алдсан хэсгээ буцаан авч 2009 оноос хойш 80 орчим хувийг нийлүүлжээ²⁹. ОХУ манай шингэн сүүний импортод голлох байр эзэлж буй нь газарзүйн ойр байрлал, бусад улс оронтой харьцуулахад тээврийн зардал хямдаас гадна хэрэглэгчид эрүүл ахуй, чанарын хувьд баталгаатай гэсэн итгэл үнэмшилтэйгээр худалдан авдагтай холбоотой байж болох юм.

Сүү, сүүн бүтээгдэхүүний импортыг бууруулах, дотоодын үйлдвэрлэлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохистой гэж үзэж байна. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор сүүний фермер болон малчдын бүлэг, хоршоодыг хөгжүүлэх, дэмжих;
- Түүхий эдээ эх орноосоо бэлдэж буй сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд Засгийн газраас татаас, хөнгөлөлт үзүүлэх;
- Түүхий сүүний бэлтгэл, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Төрөөс хуурай сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх гэх мэт.

Хөдөө аж ахуйгаас сааж буй буй сүүний бэлтгэл нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх асуудал маш чухал бөгөөд 1990-ээд оноос өмнө хот, суурин

газрын ойролцоо 800 хүртэл сайн үүлдрийн үнээний ферм байгуулах, зуны цагт хөдөө орон нутагт сүүн завод ажиллуулах гэх мэт байдлаар зохион байгуулж байв. Өнөө цагт зарим сүүний үйлдвэрүүд хот, суурин орчмын фермер болон малчидтай гэрээ байгуулан өглөө, оройн саалийн цагаар гэрээт малчдаар явж, сүү цуглуулах ажлыг хийж байна. Өдөрт дунджаар нэг малчин өрх 200 литр хүртэлх хэмжээний сүү нийлүүлж байгаа бол, зарим тохиолдолд төв суурингаас алслагдсан малчид, фермерүүд хөргөлтийн төвд сүүгээ аваачиж нийлүүлдэг байна. Бэлтгэл, нийлүүлэлтийн энэ систем нь цаг хугацаа, зардал их шаарддаг, тээвэрлэлтийн явцад сүү гашлах гэх мэт эрсдэлтэй. Орчин үед сүүний бэлтгэл нийлүүлэлтийн оновчтой тогтолцоо нь малчид, фермерээс багийн төвд сүү цуглуулах цэг, цэгээс сумын төв дэх хөргөлтийн төв, төвөөс сум дундын эсвэл аймгийн төв дэх сүүний үйлдвэр гэсэн маршрут чиглэлийг бий болгох байж болох юм. Дэлхийн зарим улс орнуудын туршлагаас харахад сүү бэлтгэн нийлүүлэгчдийг хоршоолон нэгтгэх, нийлүүлэлт, түгээлтийн цогц системийг бий болгох замаар хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, малчдыг орлогын тогтмол эх үүсвэртэй болгох ажлуудыг хийдэг.

Манай улс сүү, сүүний бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлдэг боловч энэ нь хангалттай хэмжээний урамшуулал болж чадахгүй байна. Иймд түүхий эдээ эх орноосоо бэлдэж буй сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр болон эдгээрт сүүгээ нийлүүлдэг малчдад Засгийн газраас татаас, урамшуулал үзүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлбэл үндэсний үйлдвэрлэл хөгжихийн хэрэгцээ, малчдын бизнес өргөжиж, хөдөө орон нутаг хөгжих, улмаар дотоод нөөц боломжоо бүрэн ашиглаж, зах зээлээ хамгаалах боломжтой болно. Засгийн газраас татаас, хөнгөлөлтийг олгохдоо Дэлхийн худалдааны байгууллагын өмнө авсан үүрэг амлалт, бусад улс орнуудын туршлага, өөрийн орны эдийн засгийн боломж гэх мэтийг харгалзан үзэж, тодорхой хугацаанд хэрэгжүүлснээр салбарын өрсөлдөх чадвар

²⁸ Гадаад худалдааны барааны статистик, 2003-2011оны эмхэтгэл 2011, Гаалийн Ерөнхий Газар, Улаанбаатар

²⁹ Гадаад худалдааны барааны статистик, 2003-2011оны эмхэтгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов.

дээшилж, импортийн хуурай сүүний хэмжээ буурах боломжтой.

Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний импортын тал орчим хувийг эзэлж буй хуурай сүүний үйлдвэрлэлийг дотоодод хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлснээр энэ төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах хамгийн гол нөхцөл бүрдэнэ. Хуурай сүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авахад нь хүү багатай зээл олгох, импортын татварыг нь тэглэх гэх мэт эдийн засгийн хөшүүргийг ашиглаж, салбарын үйлдвэрлэлийг дэмжих нь зохимжтой. Бид хоногт 30 тонн сүү хүлээн авч хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, түүхий эдийн судалгаа хийхэд хамгийн боломжтой 5 аймгаар Дархан-Уул, Архангай, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ шалгарч, дараагийн боломжтой 5 аймагт Булган, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Дорнод тус тус орсон. Энэ нь манай улсад сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж байгааг харуулж байна.

Энэтхэг, Пакистан зэрэг улс орнуудын туршлагаас харахад төр, бизнесийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор сүүний фермер болон малчдын бүлэг, хоршоодыг хөгжүүлэх замаар сүү, сүүн бүтээгдэхүүний салбарыг хөгжүүлж чаджээ. Эдгээр улс орнуудад малчид фермерүүд нь тархаж суурьшсан, нэг малаас саах сүүний гарц бага зэрэг байдлаараа манай улстай төстэй байна. Өндөр хүчин чадал бүхий үйлдвэрүүдээс гадна жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг салбарт чиглүүлэн, сүүгээ тушааснаар орлогын нэмэлт эх үүсвэртэй болж буйг нь малчдад ойлгуулан таниулах байдлаар бүлэг, хоршоодын үйл ажиллагааг тогтворжуулах болох юм.

Импортыг орлох сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлснээр хүнсний аюулгүй байдлыг хангаж, зах зээлд экологийн цэвэр, органик бүтээгдэхүүн нийлүүлж, нийгмийн сайн сайхан байдлыг бүрдүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, малчид болон ард иргэдийн амьжиргааны төвшинг

дээшлүүлэх, улмаар хөдөө орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг нийгэм-эдийн засгийн ач холбогдолтой.

Дүгнэлт

Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүний бэлтгэл, нийлүүлэлтийн өнөөгийн байдлыг дүгнэж харвал:

- Хүн амыг экологийн цэвэр сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах нөөц боломж манай улсад хангалттай байгаа боловч сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд хангалттай хэмжээгээр нийлүүлэх ажлыг оновчтой зохион байгуулж чадахгүй байна.
- Малыг малчдад хувьчилсан үеэс задарсан хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцоо өнөөг хүртэл оновчтой бүрдэж чадахгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна.
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхүйц цогц, өргөн далайцтай төрийн бодлого үгүйлэгдэж байгааг зохих шатанд анхаарах цаг болжээ.

Ашигласан материал

- ГЕГ, 2012. Гадаад худалдааны барааны статистик, 2011, Гаалийн Ерөнхий Газар, Улаанбаатар
- Майский И., 2001. Орчин үеийн Монгол, Улаанбаатар
- ММCG, 2010. «Сүү боловсруулах үйлдвэр»-ийн техник-эдийн засгийн үндэслэл, Бизнесийн судалгааны "ММCG" ХХК болон МУИС-ийн хамтарсан судалгааны баг, Улаанбаатар, хэвлэгдээгүй
- ҮСХ, 2012. Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл, 2011, Үндэсний статистикийн Хороо, Улаанбаатар
- ҮХААЯ-ны вэб сайт /<http://www.mofa.gov.mn/>
- ЭМЯ-ны вэб сайт /<http://moh.mn/moh%20db/order.nsf/>
- Bulletin of the International Dairy Federation 438/2009. The world dairy situation 2009. FIL-IDF, Brussels /<http://fil-fdr.org/>